

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.05.28-ны өдрийн 05 дугаар хуралдааны шийдвэрээс:

5.1. “Бүс, бүсийн төвийн ажиллах журам”-ын төслийн тухай хэлэлцээд Монгол Улсын Шадар сайдын тушаалаар шинэчлэн батлуулахаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр 2019-2024 он”-ийн төслийн тухай хэлэлцээд холбогдох засварыг хийж эргэн танилцуулахаар буцаав.

5.3. “Онцгой байдлын байгууллагын Ахмад настны хөгжил, хамгааллын хөтөлбөр”, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийн тухай хэлэлцээд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

5.4. Орхон аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт явуулсан дүнгийн тухай хэлэлцээд 91,7 хувийн үнэлгээтэй батлав. Шалгалтын дүнтэй холбогдуулан зарим алба хаагчдыг цалингийн тодорхой хувиар урамшуулахаар шийдвэрлэв.

5.5. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт явуулсан дүнгийн тухай хэлэлцээд 88,8 хувийн үнэлгээтэйгээр батлав. Шалгалтаар заагдсан нийт зөрчил, дутагдлыг 1 сарын дотор арилгаж, тайланг ирүүлэх үүргийг өгөв.

5.6. Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт явуулсан дүнгийн тухай хэлэлцээд 94,3 хувийн үнэлгээтэйгээр батлав.

5.7. Булган аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд биелэлтийн шалгалт явуулсан дүнгийн тухай хэлэлцээд 78,3 хувийн үнэлгээтэйгээр батлав. Холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэв.

5.8. Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд албаны шалгалт явуулсан дүнгийн тухай хэлэлцээд холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэв.

5.9. Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус иж бүрэн шалгалт явуулсан дүнгийн тухай хэлэлцээд 71,5 хувь буюу “С” үнэлгээтэй батлав. Холбогдох албан тушаалтнуудыг сайшаах болон сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэв.

5.10. Онцгой байдлын ерөнхий газрын даргаас цаг үеийн холбогдолтой үүрэг, чиглэлийг даргын зөвлөлийн гишүүдэд өгөв.